



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 02 сарын 04 өдөр

Дугаар Б/10

Улаанбаатар хот

Орон тооны бус зөвлөл байгуулах тухай

“Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 40 дүгээр зүйлийн 40.1, 40.4.2 дахь заалт, Албаны “Дотоод журам”-ын 1 дүгээр бүлгийн 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлуудын явц, гүйцэтгэл, хүлээн авах, хяналт тавих “Орон тооны бус зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Дэд дарга

Гишүүд: Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга


Хяналт, үнэлгээний хэлтсийн дарга

Нягтлан бодогч

Дотоод болон шуурхай ажил хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу тухайн бараа, ажил үйлчилгээ, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой тендер, гэрээний төслийг хянаж ажлын гүйцэтгэлтэй газар дээр нь танилцаж байх, дараагийн шатны санхүүжилтийг хэрхэн олгох талаар санал зөвлөмж, дүгнэлт боловсруулан албаны даргад тухай бүрт нь танилцуулж ажиллахыг “Орон тооны бус зөвлөл” -д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.БАТСАЙХАН

My documents tushaal

1170500019